



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 361

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, Ү
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 11 нэрийн, нийт 117,212,363.40 (нэг зуун арван долоон сая хоёр зуун арван хоёр мянга гурван зуун жаран гурван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 53,980,000.00 (тавин гурван сая есөн зуун наян мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн захирал Х.Энхжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001830
17-r huraldaan.docx



Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн
367 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬА ДУЛААНЫ ТЕХНИК,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛЭРТӨГГҮЙ,
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Шилтэй шкаф	2012.12.31	220,800.00	2	441,600.00	50,000.00	2	100,000.00	2
2	Диван кресло 2012	2012.12.31	358,800.00	1	358,800.00	80,000.00	1	80,000.00	2
3	Сейф хятад	2003.01.01	522,000.00	20	10,440,000.00	50,000.00	20	1,000,000.00	2
4	Ширээ хүрэн мебель	2012.12.31	138,000.00	3	414,000.00	50,000.00	3	150,000.00	2
5	Ширээ хүрэн мебель 2	2012.12.31	124,200.00	3	372,600.00	50,000.00	3	150,000.00	2
6	Ширээ цэнхэр холбоосон	2012.12.31	165,600.00	6	993,600.00	50,000.00	6	300,000.00	2
7	801675 external kit	2014.12.31	1,554,000.00	1	1,554,000.00	500,000.00	1	500,000.00	3
8	Компрессор 220В	2020-01-01	520,000.00	1	520,000.00	200,000.00	1	200,000.00	3
9	Хийн анализ XSTream XEGP	2018-12-01	97,777,763.40	1	97,777,763.40	50,000,000.00	1	50,000,000.00	3
10	6мм-ийн өндөр халаалтын гуурсан хоолой	2014.12.31	1,480,000.00	1	1,480,000.00	500,000.00	1	500,000.00	3
11	Эталон термометр	2016-03-07	2,860,000.00	1	2,860,000.00	1,000,000.00	1	1,000,000.00	3
	НИЙТ ДҮН			40	117,212,363.40 (нэг зуун арван долоон сая хоёр зуун арван хоёр мянга гурван зуун жаран гурван төгрөг дөчин мөнгө)		40	53,980,000.00 (тавин гурван сая есөн зуун наян мянга)	